



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 23 өдөр

Дугаар А/117

Шивээговь сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээний  
хугацаа сунгах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.16, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухайн хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37 дугаар зүйлийн 37.1, 37.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Ник ХХК /2075261/ нь Шивээговь сумын 1 дүгээр баг, Уурхайчдын гудамж 4-400 тоотод байрлах шатахуун түгээх станцын зориулалттай 1908м2 газрын газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулах хүсэлт гаргасан тул 15 жилийн хугацаатайгаар сунган эзэмшүүлсүгэй.

2. Хуулийн дагуу газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулан авч буй Говьсүмбэр аймаг дахь нефть хангамжийн салбарын дарга (Б.Анхбаяр)-д газрынхаа орчны тохижилтыг сайжруулж, зүй зохистой ашиглахыг үүрэг болгосугай.

3. Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг хуулийн дагуу сунгаж буй Говьсүмбэр аймаг дахь нефть хангамжийн салбарын дарга Б.Анхбаяртай газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгон хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Т.Өлзийбуд)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2008 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 58 дугаар захирамжийн 5 дахь бүртгэлийг хүчингүй болсонд тооцугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА